

ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/Жилийн эцэс/

Зуунмод
2024 он

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

НЭГ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1.1 Иргэний улсын бүртгэл
- 1.2 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
- 1.3 Хуулийн этгээдийн улсын бүртгэл
- 1.4 Бүртгэлийн хяналт
- 1.5 Архивын үйл ажиллагаа
- 1.6 Сонгуулийн үйл ажиллагаа

ХОЁР. АЖЛЫН БАЙРНЫ БОЛОН ТӨЛӨВЛӨГӨӨТ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ,

- 2.1 Сургалтын үйл ажиллагаа
- 2.2 Сурталчилгаа, олон нийтийг мэдээллээр хангах
- 2.3 Хэлтсийн мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа, вэб баяжилт

ГУРАВ. НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН БУСАД АЖЛУУД

- 3.1 Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан ажлын тайлан
- 3.2 Санхүүгийн үйл ажиллагааны тайлан
- 3.3 Хүний нөөцийн үйл ажиллагааны тайлан
- 3.4 Хэлтэст ирсэн явсан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт
- 3.5 Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах талаар хийж хэрэгжүүлсэн ажил
- 3.6 Аймаг, орон нутгийн байгууллагуудтай хамтран ажилласан байдал

ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр **13114**, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр **16913**, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр **2727** үйлчилгээ тус тус үзүүлж, **11250** тоон гарын үсэг иргэнд олгож, **4114** улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, **17901** архивын лавлагаа, мэдээлэл, хуулбар олгож давхардсан тоогоор **66019** иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

2024 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар тус хэлтэс нь улс, орон нутгийн төсөвт нийт 909,962,277.9 мөнгө оруулснаас:

- Үйлчилгээний 303,281,857.93 мөнгөний орлого оруулсан
- Тэмдэгтийн хураамжийн орлого 53,117,428.04 мөнгө
- Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны 2%-ийн татвар 540,312,992.0 мөнгө,
- Хүү, торгуулийн орлого 13,250,000.0 төгрөг тус тус төвлөрүүлсэн.

Хэлтсийн дарга Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай 2024 онд 7 зорилт, 28 хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1.1 ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2024 онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр **13114** үйлчилгээ үзүүлж, **11250** иргэнд тоон гарын үсэг олгож, **17901** архивын лавлагаа, мэдээлэл, хуулбар олгож давхардсан тоогоор **42265** иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Тоон гарын үсэг олгох ажлыг аймгийн хэмжээнд үргэлжлүүлэн зохион байгуулж 2024 онд тус хэлтэс **11250** иргэнд тоон гарын үсэг олгосон. ТГҮ олголт өмнөх оны мөн үеэс 33.7%-иар буурсан байна. 2022 оны 5-р сараас хойш 2024 оны жилийн эцсийн байдлаар Төв аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авах боломжтой иргэдээс **50938** иргэн буюу **78.0%** нь ТГҮ-ээ аваад байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2024 онд нийт **13114** бүртгэл бүртгэж, баталгаажуулснаас:

- Төрсний бүртгэл-1195
- Гэрлэсний бүртгэл-268

- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл- 70
- Үрчилсний бүртгэл- 36
- Эцэг тогтоосны бүртгэл- 59
- Овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл -61
- Нас барсны бүртгэл-577
- Гэрчилгээ дахин олголт-362
- Шинээр олгосон иргэний үнэмлэх-1296
- Дахин олгосон иргэний үнэмлэх-1217
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан- 1870
- Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл-2184 тус тус бүртгэж, баталгаажуулсан байна.

Шилжилт хөдөлгөөний бүртгэл:

1. Аймаг, нийслэлээс шилжин ирсэн
Насанд хүрэгчид- 1493
Хүүхэд-964
2. Сум дүүрэгт шилжин ирсэн насанд хүрэгч-280
Хүүхэд-255
3. Баг, хооронд шилжин ирсэн насанд хүрэгч-498
Хүүхэд-429 бүртгүүлсэн байна.

Урд оны мөн харьцуулахад иргэний улсын бүртгэл нийт дүнгээрээ 3.9%-иар өссөн байна.

2024 онд Төв аймгаас 2611 насанд хүрэгч, 1712 хүүхэд нийт **4323** иргэн бусад аймаг, нийслэл рүү шилжсэн нь Төв аймагт шилжин ирсэн иргэдээс 18.4%-иар их байна.

2024 онд иргэний улсын бүртгэл хөтөлсөн маягт, бусад эх нотлох баримтын **27308** хуудас материалыг цахимжуулж санд оруулсан.

2024 онд Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia/ -аар захиалсан **43** иргэний үнэмлэх, **9** гадаад паспортыг олгосон байна. Мөн 2024 онд /E-mongolia/ цахим порталаар шилжилт хөдөлгөөний 36 хүсэлт ирүүлснийг шалгаж 5 бүртгэлийг бүртгэж, баталгаажуулсан. Бусад нотлох баримтын шаардлага хангаагүй 31 бүртгэлийг татгалзсан тухай мэдээллийг тухай бүр иргэдэд мэдэгдэж ажилласан. Түүнчлэн E-Business цахим үйлчилгээний нэгдсэн системээр Хуулийн этгээдийн нэрийн баталгаажилтын хүсэлт **1764**, шинээр бүртгүүлэх **4** хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хүсэлтийг хүлээн авч баталгаажуулан цахим гэрчилгээ олгосон

2024 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд зөрчилтэй болон зөрүүтэй бүртгэгдсэний улмаас нөхөн бүртгүүлэх тухай 241, нэмэлт өөрчлөлт бүртгүүлэх тухай 411 нийт **652** иргэний өргөдлийг хүлээн авсан. Өргөдлийг хянан шалгахад 907 зөрчил илэрсэн.

Ирүүлсэн өргөдлийг санд шалган, нэг иргэний хэд хэдэн зөрчлийг бүгдийг арилгах зорилго тавин ажилласан бөгөөд 734 зөрчлийг нэгдсэн дүгнэлт, эх нотлох баримтыг үндэслэн мэдээллийн санд нөхөн бүртгэлээр болон засвар өөрчлөлтийн бүртгэлээр, 61 зөрчлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн тус тус арилгасан. Нийт зөрчлөөс 112-ийг УБЕГ-ын ИУБГ-т хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

Иргэний өргөдлийг бүрэн шийдвэрлэж зөрчлийг арилгасан. Шийдвэрлээгүй өргөдөл байхгүй.

1.2. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Иргэн, хуулийн этгээдээс 16913 мэдүүлэг хүлээж авч 16049 мэдүүлэг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системд боловсруулан бүртгэл хийж архивт шилжүүлсэн. Үүнээс 10493 нь газар өмчлөх эрхийн, 5556 нь газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдүүлэг байна.

Газар өмчлөх эрхийн улсын бүртгэлтэй холбогдолтой үйлчилгээний 10493 мэдүүлэг боловсруулж бүртгэл хийснээс:

- Төрөөс үнэгүй өмчлүүлсэн газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 2726
- Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцэлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүссэн анхны бүртгэл 116 ,
- Төрөөс худалдаж авсан газар өмчлөх эрхээ бүртгүүлсэн 6,
- Газар худалдах, худалдан авах гэрээний эрхийн бүртгэл 2550,
- Газар бэлэглэлийн гэрээний эрхийн бүртгэл 397,
- Өв залгамжлах эрхийн бүртгэл 223,
- Хамтран өмчлөгч өөрчлөгдсөн бүртгэл 76,
- Арилжаа солилцооны гэрээ 7,
- Албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 1,
- Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 4,
- Газар эзэмших эрх газар өмчлөх эрх болж өөрчлөгдөх бүртгэл 2
- Газар барьцаалсан барьцааны гэрээний бүртгэл 1909,
- Барьцааны гэрээ дуусгавар болох бүртгэл 1839,
- Үрэгдүүлсэн гэрчилгээ нөхөн олгосон бүртгэл 120,
- Бусад өөрчлөлт хийгдсэн 517 бүртгэл хийж газар өмчлөх эрхийн 6616 гэрчилгээний үнэт цаас зарцуулсан байна.

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээний 5556 мэдүүлэг боловсруулж бүртгэл хийснээс:

- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх бүртгэл 525
- Төрөөс хувьчилсан орон сууц өмчлөх эрхийг баталгаажуулах 8
- Шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийн 220
- Гэрээ хэлцэлийн үндсэн дээр бүртгэл салж үүссэн анхны бүртгэл 21

- Төрөөс худалдаж авсан үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх бүртгүүлсэн 3
- Худалдах худалдан авах гэрээний бүртгэл 457
- Бэлэглэлийн гэрээ 83
- Албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх 3
- Өв залгамжлах эрхийн гэрээний бүртгэл 87
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх хэлцэл 83
- Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 7
- Өмчлөгчийн үүсгэн байгуулсан хуулийн этгээдээс иргэнд, иргэн үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн өмчлөлд өмчлөх эрх шилжих 2
- Барьцаат зээлийн гэрээний бүртгэл 523
- Барьцаалбартай барьцааны гэрээний бүртгэл 1497
- Барьцааны гэрээ дуусгавар болсон бүртгэл 1792
- Үрэгдүүлсэн гэрчилгээ нөхөж олгосон бүртгэл 18
- Түрээсийн гэрээ 2
- Бүртгэлд өөрчлөлт 225 бүртгэл тус бүр хийсэн байна. Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн 1655 гэрчилгээ зарцуулсан.

Газар өмчлөх эрхийн гэрчилгээ үрэгдүүлсэн 120, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ үрэгдүүлсэн 18 нийт 138 гэрчилгээг хүчингүйд тооцуулах хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж гэрчилгээг нөхөн бичиж өмчлөгч нарт олгосон. Мөн ерөнхий бүртгэгчийн А/1614 тоот тушаалаар 39, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 2 хувийн хэргийг хаах бүртгэл хийсэн.

2024 оны жилийн эцсийн байдлаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан мэдүүлгээс нотлох баримтын шаардлага хангаагүй 813 мэдүүлгийг буцаасан. Газар өмчлөх эрхийн бүртгэлтэй холбоотой буцаж буй мэдүүлгийн тоог буруулах зорилгоор хэлтсээс 2024 оны 584 тоот зөвлөмжийг аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн. Үүний үр дүнд хавсаргавал зохих нотлох баримт дутуу, засвартай, мэдээлэл зөрүүтэй захирамж, газрын кадастрын зураг, хянан баталгааны дүгнэлт эрс буурсан.

Төв аймгийн орон сууц хувьчлах товчооноос 1997-2013 оны хооронд нийт 1062 иргэнд орон сууц хувьчилснаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд 927 иргэний төрөөс хувьчилсан орон сууц баталгаажиж 135 иргэн төрөөс хувьчлан авсан орон сууцаа баталгаажуулаагүй байсан. 2023 онд тухайн ажлыг эхлүүлснээр 22 иргэний төрөөс хувьчилсан орон сууцыг баталгаажуулсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 11 иргэн төрөөс хувьчилсан орон сууцаа улсын бүртгэлд бүртгүүлж, баталгаажуулснаар нийт 33 иргэн цэнхэр ордерийг солиулж аваад байна.

2024 он гэхэд Төв аймгийн 6 суманд эд хөрөнгийн эрхийн 3 суманд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумаас үзүүлж байсан ба энэ онд Заамар, Сэргэлэн сумын иргэний улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

хөтлөх, Борнуур сумын иргэний улсын бүртгэгчид хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх давхар нээлгэж нийт 8 сумын улсын бүртгэгч эд хөрөнгийн эрхийн, 4 сумын улсын бүртгэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг хамт үзүүлж байна. Тус хэлтсийн 2024 онд хөтөлсөн эд хөрөнгийн эрхийн 16049 улсын бүртгэлийн 5548 бүртгэл буюу 34.6%-ийг дээрх 8 сумдаас үзүүлж иргэд аймгийн төв орох зардал, хугацааг хэмнэж ажилласан.

1.3.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2024 онд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт **2727** бүртгэл хөтөлсөн. Үүнээс: Шинээр үүсэн байгуулагдсан **635**, нэмэлт өөрчлөлт **468**, салбар, төлөөлөгчийн газрын бүртгэл **8** тус тус бүртгэгдсэн байна.

Шинээр үүсэн байгуулагдсан 635 хуулийн этгээд бүртгүүлснийг хэлбэрээр нь ангилбал:

- ХХК-112,
- ТББ-19,
- Нөхөрлөл-10,
- Хоршоо-489,
- Үйлдвэрчний эвлэл-2,
- Төрийн байгууллага-2
- Орон нутгийн өмчит ААТҮГ-1 тус тус бүртгүүлсэн.

Нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд нийт **468** хуулийн этгээд бүртгүүлснийг хэлбэрээр нь ангилбал:

- Үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн-188
- Эцсийн өмчлөгч-5
- Дүрэм шинэчилсэн-8
- Дахин гэрчилгээ олгосон-129
- Удирдлага өөрчлөгдсөн-44
- Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн-34
- Дүрмийн сан-15
- Нэр хэлбэр өөрчлөлт-8
- Хаягийн өөрчлөлт-18
- Татан буугдсан-9
- Хориг тавигдсан – 2,
- Хориг цуцалсан-8

Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар 8, бүртгэгдсэнээс:

- ХХК - 5

- НҮТББ -3
- салбар төлөөлөгчийн газрын өөрчлөлтийн бүртгэл-8 байна.

Хуулийн этгээд байгуулахаар оноосон нэр авах хүсэлт гаргасан 784 иргэнд хүсэлтийн дагуу нэр олгож баталгаажуулсан. Мөн хуулийн этгээдийн тамга тэмдгийн хяналтын дугаар 726-ийг олгож 75 хуулийн этгээдийн тамга тэмдгийг хураан авсан байна. 2024 онд байдлаар иргэн, хуулийн этгээдэд 106 лавлагаа, хуулбар олгосон.

Мөн 2024 онд “Шинэ хоршоо хөдөлгөөн” явагдаж сумдыг бүлэг болгон ойр байрлах сумын бүртгэлүүдийг иргэдэд ойртуулж, Баянцогт сумын улсын бүртгэгч 108, Борнуур сумын улсын бүртгэгч 53, Лүн сумын улсын бүртгэгч 160, Зуунмод сумын улсын бүртгэгч 69 хоршоог тус тус бүртгэж нийт 390 хоршооны бүртгэлийг суманд бүртгэсэн.

1.4 БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тус хэлтсийн 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг 9 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллав.

2024 онд иргэний бүртгэлийн 2302 бүртгэлд, эд хөрөнгийн эрхийн улсын 1535 бүртгэлд, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 277 бүртгэлд тус тус хяналт тавьж, ХША-1 маягтаар баталгаажуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль болохтой холбоотойгоор 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 08 дугаар сарын 09-ны өдрийг дуустал хугацаанд бүртгэсэн 984 шилжих хөдөлгөөний бүртгэлийг бүрэн хянасан. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн цахимжуулалттай холбоотой зөрчлийг тухай бүр арилгуулан ажилласан.

Тайлангийн хугацаанд иргэний улсын бүртгэлтэй холбоотой 83, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 151, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 8, нийт 242 улсын байцаагчийн дүгнэлт гаргасан байна. Үүнээс:

- Регистрийн дугаарыг хүчингүй болгосон-35,
- Иргэний улсын бүртгэл хүчингүй болгосон-23,
- Иргэний улсын бүртгэлд өөрчлөлт оруулах-25.
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон-144
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулах-7
- Тамга тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох-8 дүгнэлт тус тус гаргажээ.

Тайлангийн хугацаанд 10 улсын бүртгэгчид бүртгэлийн зөрчлийг ХША-2 маягтаар танилцуулж, хариу тайлбар авсан. Арилгах боломжтой зөрчлийг газар дээр нь арилгуулсан. Зөрчлийг арилгахтай холбоотой 2 албан шаардлага нийт 11 улсын бүртгэгчид хүргүүлэв.

Аргалант, Архуст, Алтанбулаг, Баян, Баянчандмань, Баянжаргалан, Баянцогт, Баянхангай, Борнуур, Бүрэн, Жаргалант, Зуунмод, Заамар, Өндөрширээт, Эрдэнэсант, Угтаалцайдам суман дахь иргэний улсын бүртгэгч нарын бүртгэлийн үйл ажиллагаанд, хэлтсийн эд хөрөнгийн эрхийн 4 улсын бүртгэгчийн бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийж нийт 1722 бүртгэлд хяналт тавьж, 74 зөрчлийг илрүүлэн арилгуулсан байна.

Хяналт тавьсан нийт бүртгэлийн 4.29% нь зөрчилтэй байснаар улсын бүртгэлийн зөрчлийг урд оноос 15%-иар бууруулсан байна.

2024 оны эхний хагас жилд улсын бүртгэлийн 115 архивын хувийн хэрэг, журналд хяналт тавьсан байна.

2024 оны 01 дүгээр сард 24 сумын улсын бүртгэгч нарын иргэнд олгосон гэрлэсний 35 лавлагааг түүвэрлэн шалгахад иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд гэрлэсний бүртгэлийг тусгасныг үндэслэн олгосон байх бөгөөд мэдээллийн санд болон хувийн хэрэгт эх нотлох баримт байхгүй байхад гэрлэсэн тухай лавлагаа олгосон 1 лавлагаа байсан. Тус лавлагааг олгосон Цээл сумын улсын бүртгэгч Г.Мөнхцэцэгт цаашид анхаарч ажиллахыг сануулсан.

Тайлангийн хугацаанд Баян-Өнжүүл сумын иргэний улсын бүртгэгчээс олгосон 176 лавлагаа, Бүрэн сумын иргэний улсын бүртгэгчээс олгосон 52 лавлагааг бүртгэлийн дэвтэр болон мэдээлэл удирдах-цахим архивын программаас тулгаж хянахад зөрчил илрээгүй.

2024 онд иргэдээс болон улсын бүртгэгч нараас лавлагааны зөрчилтэй холбоотой өргөдөл, мэдээлэл хяналын улсын байцаагчид ирээгүй.

2024 онд улсын бүртгэл хөтөлсөн 4114 бүртгэлийн цахимжуулсан эх нотлох баримт болон улсын бүртгэлийн 378 лавлагаанд хяналт тавихад 124 зөрчил илэрсэн нь 2.8%-ийг эзэлж байна.

Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 4 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангаж нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй, компьютерт нууц үг тохируулан ашиглах талаар улсын бүртгэгч нарт үүрэг өгч, иргэний улсын бүртгэгч нарыг анхны тохиргоогоор байгаа нууц үгийг бүрэн солиулсан. Мэдээлэл технологийн сангийн аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн ашиглалтын байдалтай холбоотой эрсдлийг тодорхойлон мэдээлэл технологийн ажилтан хэлтсийн бүх албан хаагчийн компьютерийн үзүүлэлтийг шалгаж тэмдэглэл хөтөлсөн ба засвар шинэчлэлт

шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргасан. 29 удаа хэлтсийн болон сумдын бүртгэлийн сүлжээ тасалдсаныг цаг тухай бүрт нь холбогдож хэвийн ажиллагааг хангасан, 11 сумын бүртгэлийн сүлжээ доголдолтой байсныг цаг тухай бүрт нь холбогдож хэвийн ажиллагааг хангасан.

25 сумын иргэний улсын бүртгэгчийн civilreg программд шинэчлэл хийсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд хурууны хээгээр мэдүүлэг авах боломжгүй байсан 3 бүртгэгчийн доголдлыг арилгасан байна. Улсын бүртгэгч нарыг эрсдлээс хамгаалж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Цагдаагийн газар, Тагнуулын газрын холбогдох албан хаагчдаар 4 удаагийн сургалт зохион байгуулсан. Мөн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд анхаарах асуудлуудаар улсын ахлах бүртгэгч нар сумдын улсын бүртгэгчдэд 3 удаа тус тус цахим сургалт зохион байгуулсан

2024 онд 520 иргэн, хуулийн этгээдэд холбогдох зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 14,120.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Зөрчлийн төрлийг тоо (хувиар) ангилбал:

- Иргэний улсын бүртгэлд тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй зөрчил-450 (86%)
- Иргэний үнэмлэх гээсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн-53 (10%)
- Хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт оруулсныг хугацаанд нь бүртгүүлээгүй, тамга тэмдэг гээгдүүлсэн зэрэг– 17 (4%) байна.

Зөрчлийн улмаас төр, иргэнд учирсан хохирол байхгүй. Холбогдогчид шийтгэлийг бүрэн биелүүлсэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх хуудсаар албадан хэрэгжүүлсэн торгууль байхгүй, бүрэн хэрэгжсэн байна.

Хянан шийдвэрлэсэн зөрчлийн тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 432 байсан бол энэ оны хувьд 520 болж, 20 хувиар өссөн байна. Сумын төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлого өнгөрсөн онд 9,2 сая төгрөг байсан бол мөн онд 14,1 сая болж 53 хувиар өссөн байна Энэ нь хуулийн этгээдийн зөрчлийг илрүүлэн шийдвэрлэдэг болсонтой холбоотой байна.

1.5 АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Тус хэлтсийн иргэний баримтын архивт 87747 иргэний, 0-16 насны хүүхдийн 36643, нас барсан иргэдийн 38112, биеийн давхцахгүй өгөдлийн бүртгэлд хамрагдаагүйгээс мэдээллийн санд тодорхойгүй төлөвтэй 8134 иргэний хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна. 2024 онд **12506** иргэний хувийн хэргийг цахимжуулсан эсэхийг мэдээллийн санд шалгалаа. Шалгалтаар 893 нас барсан иргэний хувийн хэрэг татагдаагүй байсныг нас баралтын сан руу шилжүүлсэн. Мөн 1502 иргэний хувийн хэрэг огт цахимжаагүй байсан. Огт цахимжаагүй байсан **1502** иргэний хувийн хэргийн Б талыг архиваас татан цахимжуулсан.

Түүнчлэн 2024 онд иргэний улсын бүртгэл хөтөлсөн **13114 бүртгэлийн 27308** хуудас нотлох баримтыг бүртгэл хөтөлсөн даруйд цахимжуулж ажилласан.

Тайлангийн хугацаанд хөтөлсөн иргэний улсын бүртгэлээс эх нотлох баримтыг цахимжуулаагүй үлдсэн бүртгэл байхгүй.

Тайлангийн хугацаанд УБЕГ-ын ИУБГ-аас иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд ирүүлсэн нас барсны болон төрсний бүртгэл нь санд цахимжаагүй 1007 иргэний хувийн хэрэг, журналыг хэлтсийн иргэний баримтын архиваас татан цахимжуулсан.

Иргэний баримтын архивын тодорхойгүй, мэдээлэл байхгүй, хүчингүй төлөвт байгаа эх нотлох баримтыг хадгаламжийн нэгжийн бүртгэлд оруулж тайлангийн хугацаанд 8134 иргэний хувийн хэргийг бүртгэлжүүлж 209 хайрцаг хадгаламжийн нэгж үүсгээд байна. Тус хэлтсийн иргэний баримтын архив дахь тодорхойгүй, мэдээлэл байхгүй, хүчингүй төлөвт байгаа иргэдийн хувийн хэргийг хадгаламжийн нэгжийн бүртгэлд бүрэн оруулсан.

Иргэний баримтын архивт хадгалагдаж байгаа 38112 нас барсан иргэдийн хувийн хэргийг архивын хадгаламжийн нэгжийн бүртгэлд оруулах ажлыг 2024 онд эхлэн тайлангийн хугацаанд 12592 иргэний хувийн хэргийн 35889 маягтыг бүртгэлжүүлж 315 хайрцаг хадгаламжийн нэгж үүсгээд байна. Нас барсан иргэдийн хувийн хэргийн 33.0%-ийг хадгаламжийн нэгжийн бүртгэлд оруулаад байна.

1.6. Сонгуулийн үйл ажиллагаа

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, Улсын бүртгэлийн ерөнхий газраас гаргасан ерөнхий төлөвлөгөөний хүрээнд Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хийж хэрэгжүүлэх 30 арга хэмжээ бүхий дэд төлөвлөгөө, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж 27 арга хэмжээ бүхий дэд төлөвлөгөө тус тус гаргаж **хэрэгжилтийг 100% бүрэн хангаж ажилласан.**

Дэд төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд 3 удаа онлайн сургалт, 2 удаа танхимын сургалт зохион байгуулж, хийж хэрэгжүүлсэн ажлын 24 илтгэх хуудсыг УБЕГ-т хүргүүлсэн.

МУИХ-ын болон АНСДИТХ-ын сонгуулийн үйл ажиллагааны явцад Төв аймгийн УБХ, улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудтай холбоотой ямар нэг гомдол, санал гараагүй.

УИХ-ын болон АНСДИТХ-ын сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх дэд ажлын төлөвлөгөөний хэрэгжилтүүдийг хавсаргав.

ХОЁР. ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН АЖЛЫН БАЙРНЫ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ

2.1 Сургалтын үйл ажиллагаа

Улсын бүртгэлийн талаар төрөөс баримталж буй бодлого, бусад салбарын эрх зүйн шинэчлэл, цаашид анхаарах асуудлын талаар албан хаагчдад мэдээлэл өгч , мэдлэг олгох зорилготой хэлтсийн 2024 оны сургалтын төлөвлөгөөг 17 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлангийн хугацаанд дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

Улсын бүртгэлийн талаар төрөөс баримталж буй бодлого, бусад салбарын эрх зүйн шинэчлэл, цаашид анхаарах асуудлын талаар албан хаагчдад мэдээлэл өгч , мэдлэг олгох зорилготой хэлтсийн 2024 оны сургалтын төлөвлөгөөг 17 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллав. 2024 онд бусад төрийн байгууллагын албан хаагчидтай хамтран хэлтсийн албан хаагчид болон итгэмжлэгдсэн ажилтнуудад 21 удаагийн танхим, 29 удаагийн цахим сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 641 албан хаагчид хамрагдсан байна.

2024 онд УБЕГ-аас зохион байгуулсан дараах сургалтуудад холбогдох албан хаагчдыг бүрэн хамрууллаа. Үүнд:

1. МУИХСтХ-д орсон онцлог зохицуулалт” цахимаар УБЕГ (2024.01.25 эмэгтэй 27)
2. “Сөрөг мэдээлэл, сөрөг зүйлээс өөрийгөө хамгаалахуй” цахимаар УБЕГ (2024.01.26, эмэгтэй 26)
3. “Сонгуулийн тухай хууль, холбогдох журмын танилцуулга” цахимаар УБЕГ (2024.03.22, эмэгтэй 27)
4. “Е-монголиа системээр шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал” цахимаар УБЕГ (2024.04.10, эмэгтэй 27)
5. “Та10201-мон Азийн хөгжлийн банкны төслийн нээлтийн семинар” цахимаар УБЕГ (2024.04.04, эмэгтэй 24)
6. “Нас барсны бүртгэл, дундын мэдээллийн сан ашиглаж хөтлөх тухай” цахимаар УБЕГ (2024.04.17, эмэгтэй 24)
7. “Эрүүл мэндийн сургалт” цахимаар УБЕГ (2024.04.18 эмэгтэй 24)
8. “Архивын лавлагаа олгох, цахижуулах сургалт” цахимаар УБЕГ (2024.04.18 эмэгтэй 24)
9. “Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээд, эд хөрөнгийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч нарт зориулсан сургалт” цахимаар УБЕГ (2024.04.26 эмэгтэй 1)
10. “Хоршооны улсын бүртгэл” цахимаар УБЕГ (2024.05.01, эмэгтэй 24)
11. Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтны сургалт” цахимаар Улсын бүртгэлийн хэлтэс, Тагнуулын хэлтэстэй хамтран (2024.05.24, нийт 87)

12. “Албан хэрэг хөтлөлтийг оновчтой зохион байгуулах, баримт бичиг зохион бүрдүүлэх нь” цахимаар УБЕГ (2024.05.30 эмэгтэй 1)
13. “Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим үйлчилгээг нэтрүүлэх замаар төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах-ТА10201-МОН” төслийн хүрээнд зохион байгуулсан бүсчилсэн сургалтад (Баян-Өлгий аймагт 08 сарын 22, 23-ны өдрүүдэд, эрэгтэй 2, эмэгтэй 15)
14. БНСУ-д КОЙКА төслийн хүрээнд туршлага судлах, чадавхижуулах сургалтад иргэний улсын ахлах бүртгэгч П.Болормаа (2024.09.02-15-ны өдрүүдэд Солонгос улсад)
15. “Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтны сургалт” цахимаар Улсын бүртгэлийн хэлтэс, Мэдээлэл технологийн газартай хамтран (2024.09.30, нийт 100)
16. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас суман дахь иргэний улсын бүртгэгч нарт зориулсан- 5 удаагийн цахим сургалт (нийт 100)

Тайлангийн хугацаанд УБЕГ-аас зохион байгуулсан 18 удаагийн цахим сургалт, 2 удаагийн танхимын сургалтад давхардсан тоогоор 534 албан хаагчид хамрагдсан байна.

Сургалтын төлөвөлөгөөний хэрэгжилтийг хавсаргав.

2.2 Сурталчилгаа, олон нийтийг мэдээллээр хангах

2024 онд Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл болон Монгол Улсын Их Хурлын сонгууль, Аймаг нийслэл сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуультай холбогдуулан тус хэлтсээс 12 видео мэдээлэл /контент/-г бэлтгэн Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Facebook, web хуудас болон аймгийн TBS, Төв телевизүүдээр дамжуулан иргэд олон нийтэд хүргэсэн. Үүнд:

1. Иргэний үнэмлэхний шинэ, 25,45 насны сунгалтын бүртгэлийн талаарх шторк (2024.01.04)
2. Иргэний улсын бүртгэлийн талаарх шторк (2024.03.14), (2024.08.15)- 2 ш
3. Эд хөрөнгийн бүртгэлийн талаарх шторк (2024.03.11), (2024.08.05), (2024.08.27) -3ш
4. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг burtgel.gov.mn вэб хуудсанд байрлуулсан, сонгогч өөрийн болон өөрийн байнга оршин суух хаягийн бүртгэлтэй иргэдийн мэдээлэлтэй хэрхэн танилцах тухай шторк (2024.04.10)
5. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоох тухай богино хэмжээний дүрст мэдээг (2024.04.10)

6. Улсын бүртгэлийн 24/7 киоск машиныг танилцуулсан зурагт мэдээ (2024.02.01)
7. Аймгийн TBS телевизэд хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч нар үндсэн үйл ажиллагаа болон цаг үеийн ажлын талаар дүрст мэдээ өгч олон нийтэд хүргэлээ. (2024.05.02)
8. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаарх шторк (2024.08.20)
9. Ногоон нэгж аяны хүрээнд бэлтгэсэн контент (2024.10.28)

2.3 Хэлтсийн мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа, вэб баяжилт

Хэлтсийн 2024 оны ил тод байдлыг хангах ажлын төлөвлөгөөг 7 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр болосвруулан хэрэгжилтийг ханган ажилласан. Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог хангах зорилгоор олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна. **Тайлант хугацаанд:** “Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудас нь 3020 дагагчтай байгаа бол <http://tuv.burtgel.gov.mn/> веб хуудас нь нийт 6396 хэрэглэгчдийн хандалт авсан байна.

- <http://tuv.burtgel.gov.mn/> веб хуудсанд нийт 159 мэдээ мэдээллийг нийтэлсэн.
 - Санхүүгийн ил тод байдлын талаар 12
 - Хурал, сургалт, семинар, хэлэлцүүлгийн талаар 7
 - Жил, улирлын тайлан 2
 - Нээлттэй ажлын байрны зар 6
 - Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байдлаар 9
 - Сар бүрийн статистик тоон мэдээ 10
 - Түгээмэл асуулт хариулт 12
 - Цаг үеийн мэдээ /хэлтэс, орон нутагтай холбоотой мэдээ мэдээлэл/ 65
 - Видео мэдээ /хэлтэс, орон нутагтай холбоотой мэдээ мэдээлэл / 20
 - Топ мэдээ 16

“Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудсанд шторк, хэвлэн олшруулж боломжтой материал, инфографик зэргээр нийт 105 мэдээ мэдээллийг нийтэлсэн. 2024 оны 10 сарын 31-ны байдлаар шилэн дансны цахим сайтад 171 мэдээлэл оруулахаас 171-ыг хугацаа хоцролгүй, үнэн зөв байршуулсан.

Хэлтсийн ил тод байдлыг хангах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсаргав.

ГУРАВ. НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан ажлын тайлан:

2024 онд Төв аймгийн 26 суманд хэлтсийн албан хаагчид болон сумдын улсын бүртгэгч нар “НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” зохион байгуулж иргэний бүртгэлийн чиглэлээр—457, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр— 515, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр—126 иргэнд үйлчилгээ үзүүлж, 1250 иргэнд ТГҮ олгож, 3950 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. **Үүнээс:**

А/ Хэлтсээс зохион байгуулсан.

1. Баянцагаан суманд 2024 оны 01 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд “НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” зохион байгуулж Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж нийт 107 иргэнд тоон гарын үсэг олгож, эд хөрөнгө, хуулийн этгээдийн мэдээлэл зөвлөгөөг хүргэж ажиллалаа.

2. “Цахимд хэвшье” уриатайгаар үндэсний хэмжээнд өрнөж байгаа Digital first – D1 арга хэмжээний хүрээнд Мөнх-Алдарын талбайд зохион байгуулсан үзэсгэлэнгийн арга хэмжээ 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр оролцлоо.

3. 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Төв аймгийн Нэгдсэн үйлчилгээний төвд “Хуульчдын про-боно” хууль зүйн туслалцааны арга хэмжээний хүрээнд оролцлоо.

4. Эрдэнэ суманд 2024 оны 05 дугаар сарын 16,17-ны өдрүүдэд “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдөрлөг зохион байгуулж иргэний гадаад паспортын бүртгэл 45 иргэн, эд хөрөнгийн бүртгэл, зөвлөгөө 84 иргэнд, хуулийн этгээдийн бүртгэл 13 иргэн, хоршоонд заавар зөвлөгөө өгч бүртгэлийн үйлчилгээг нэг дороос үзүүлэн ажиллалаа.

5. Борнуур суманд 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдөрлөг зохион байгуулж гадаад паспортын бүртгэл 22 иргэн, эд хөрөнгийн бүртгэл, зөвлөгөө 110 иргэнд, хуулийн этгээдийн бүртгэл 50 иргэн, хоршоонд заавар зөвлөгөө өгч бүртгэлийн үйлчилгээг нэг дороос үзүүлэн ажиллалаа.

6. Алтанбулаг суманд 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан “Малчдын нэгдсэн зөвлөгөөн”-д зөврийн тоног төхөөрөмжөөр иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.

7. Баяндэлгэр суманд 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулагдсан “Малчдын нэгдсэн зөвлөгөөн”-д зөврийн тоног төхөөрөмжөөр иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв.

8. Алтанбулаг суманд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан “Нийгмийн салбарын” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон зөврийн тоног төхөөрөмжөөр иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв.

9. Борнуур суманд 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан “Нийгмийн салбарын” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон зөөврийн тоног төхөөрөмжөөр иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв.

10. Заамар суманд 2024 оны 10 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулсан “Нийгмийн салбарын” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон зөөврийн тоног төхөөрөмжөөр иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв.

Б/ Сумдын улсын бүртгэгч нарын зохион байгуулсан.

1. Баянчандмань суман дахь иргэний улсын бүртгэгч 2024.03.24-нд Эрдэнэ 3-р баг, 05.25-нд Замт 2-р баг, Эрдэнэ 3-р баг, 2024.11.18-нд Эрдэнэ 3-р багийн ИНХ-д оролцож иргэний улсын бүртгэл болон эд хөрөнгийн бүртгэлийн талаар нийт 64 иргэнд мэдээлэл хүргэсэн.

2. Аргалант суман дахь иргэний улсын бүртгэгч 2024.04.23-нд Баянцогт суманд ажиллаж газар 43, үл хөдлөх хөрөнгийн 3 нийт 45 мэдүүлэг хүлээн авч, эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн. Шинэ хоршоо төслийн багтай хамтран сумын 6 малчдын бүлгүүдэд шинээр хоршоо бүртгүүлэхтэй холбоотой зөвлөгөө мэдээллүүдийг 120 иргэнд хүргэсэн.

3. Батсүмбэр суман дахь иргэний улсын бүртгэгч 2024.05.07-нд Батсүмбэр сумын “Малчин тариаланчдын зөвлөгөөн”-д оролцсон 150 иргэнд хоршоо байгуулахад бүртгүүлэх талаар гарын авлага хүргэсэн. Нийгмийн салбарын явуулын үйлчилгээ 2024.09.25 ны өдөр нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж Иргэний бүртгэл болон Эд хөрөнгийн чиглэлээр 35 иргэнд зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан.

4. Баянцогт суман дахь иргэний улсын бүртгэгч 2024.05.08-нд Гуна багийн, 05.02-нд 3 дугаар багийн ИНХ-д оролцож, 78 иргэнд тоон гарын үсэн олгож, шилжих хөдөлгөөний бүртгэл, хоршооны бүртгэлийн талаар мэдээлэл хийсэн. 2024.05.02-ны өдөр Даргиат баг, 2024.05.08-нд Гуна 1-р баг, 2024.05.14-нд Сарлаг 2-р багийн ИНХ-д тус тус оролцож, нийт 178 иргэнд шинэ хоршоо байгуулах, ТГҮ олголт, газар болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авахад бүрдүүлэх материал, харъяалал харгалзах 5 бүртгэл, харъяалал харгалзахгүй 10 бүртгэлийн төрөл, мөн УИХ-ын ээлжит сонгуультай холбогдуулан ШХ-ний бүртгэл түр зогсоох, сэргээх талаар мэдээлэл бэлтгэн иргэдэд танилцуулга хийж гарын авлага тараасан

5. Эрдэнэ суман дахь иргэний улсын бүртгэгч 5 багийн 960 гаруй иргэнд сонгогчийн нэрийн жагсаалтад өөрийн мэдээллээ шалгах, шилжих хөдөлгөөний бүртгэл, тоон гарын үсгийн талаар мэдээлэл хүргэн ажилласан.

6. Баянжаргалан суман дахь улсын бүртгэгч Жаргалант 1 дүгээр багийн ИНХ-д оролцож, тоон гарын үсэг, хоршоо байгуулахад бүрдүүлэх материал, иргэний бүртгэлийн хугацаа хэтрүүлсэн зөрчлийн талаарх мэдээлэл хүргэсэн. УБЕГ-аас болон хэлтсээс гаргасан шторк, ярилцлага мэдээллүүдийг орон нутгийн

мэдээллийн хаягуудад share хийж байршуулдаг. Хоршоо байгуулахаар сонирхсон иргэдэд хэлтсээс ирүүлсэн гарын авлага материалыг олшруулж, хэвлэж гарын авлага болгон өгсөн. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий суманд ажиллаж байгаа багтай хамтран ажилласнаар шинээр байгуулагдсан 5 хоршооны 89 иргэнд хоршоо шинээр бүртгүүлэх болон нэмэлт өөрчлөлт нэмэх, хасах, бүртгэлтэй холбоотой материалын жагсаалтыг хэвлэж, мэдээллийг өгч ажилласан. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар сумын группт шторк хийж тавьсан.

7. Алтанбулаг суман дахь иргэний улсын бүртгэгч 2024.05.14-нд сумын 1, 2-р багуудын ИНХ-д оролцож 210 иргэнд, 2024.05.15-нд 3,4-р багийн 110 иргэнд иргэний бүртгэлийн хууль тогтоомж, тоон гарын үсгийг хэрхэн олгох, ашиглах талаар, иргэний бүртгэлийн хугацаа хэтрүүлсэн тохиолдолд зөрчлийн хуулиар авах арга хэмжээний талаар, сонгогчийн нэрийн жагсаалтад өөрийн мэдээллээ шалгах талаарх мэдээллийг болон хоршоо шинээр бүртгүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, хасах бүртгэлтэй холбоотой мэдээллийг хүргэж тайлбарлан ажилласан.

8. Жаргалант суман дахь иргэний улсын бүртгэгч 2024.06.30-нд Буурал 1-р багийн ИНХ-д оролцож 84 иргэнд тоон гарын үсгийг хэрхэн олгох, ашиглах талаар, иргэний бүртгэлийн хугацаа хэтрүүлсэн тохиолдолд зөрчлийн хуулиар авах арга хэмжээний талаар, сонгогчийн нэрийн жагсаалтад өөрийн мэдээллээ шалгах талаарх мэдээллүүдийг хүргэж ажилласан. Хоршоо байгуулахад бүрдүүлэх материалын жагсаалтыг ЗДТГ-ын мэдээллийн самбарт байршуулж, иргэдэд зөвлөгөө мэдээллийг хүргэж ажиллаж байна.

9. Цээл суман дахь улсын бүртгэгч 2024.06.30-нд 1, 2, 3, 4, 5-р багийн ИНХ-д оролцож 152 иргэнд иргэний бүртгэлийн хууль тогтоомжийн талаар, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд зөрчлийн хуулиар авах арга хэмжээний талаар, хоршоо шинээр бүртгүүлэх болон нэмэлт өөрчлөлт, хасах бүртгэлтэй холбоотой мэдээллүүдийг тайлбарлан мэдээллийг хүргэж ажилласан. Мөн хоршоо байгуулахад бүрдүүлэх материалын жагсаалтыг 10 иргэнд гаргаж өгөн, шаардлагатай зөвлөгөө мэдээллийг хүргэж ажилладаг

10. Баянхангай суман дахь иргэний улсын бүртгэгч 2024.05.14-наас 2024.05.20-нийг дуустал 6 хоногийн хугацаанд Шинэ хоршоо төслийн багтай хамтран, тус сумын 11 малчдын бүлэгт шинээр хоршоо бүртгүүлэх, болон гишүүн нэмэх хасах өөрчлөлт орох бүртгэлтэй холбоотой зөвлөгөө мэдээллүүдийг нийт давхардсан тоогоор 203 иргэнд хүргэж ажилласан. 2024.10.01-нд сумын ахмадын баярын хүндэтгэлийн хуралд бусад төрийн албан хаагчидтай хамтран 66 иргэнд иргэний бүртгэлийн хууль тогтоомжийн талаар тоон гарын үсгийг хэрхэн олгох, авах, ашиглах талаарх зөвлөгөө мэдээллүүдийг хүргэж ажилласан.

11. Дэлгэрхаан суман дахь иргэний улсын бүртгэгч ерөнхий боловсролын сургуулийн 10-11-р ангийн 16 сурагчид Зөрчлийн тухай хууль, иргэний үнэмлэхийн болон гадаад паспортын бүртгэлийн талаар мэдээлэл хийж, 16 ш гарын авлага материал тараасан. Дуут-Хуримт 2-р багийн ИНХуралд оролцож, 65 иргэнд шилжилт хөдөлгөөний бүртгэл, тоон гарын үсэг олгох, сонгуулийн нэрсийн жагсаалтаас өөрийн мэдээллээ хэрхэн харах болон бусад цаг үеийн талаархи

мэдээллийг хүргэж, хоршоог улсын бүртгэлд бүртгэлд бүртгүүлэхэд анхаарах асуудлаар сургалт мэдээлэл хийсэн, нийт 39 гарын авлага, материал тараасан. Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ хоршоо” хөтөлбөрийн хүрээнд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий суманд ажиллаж байгаа багтай хамтран Давст 3-р багийн хөдөөгийн айл өрхөөр явж 51 иргэнд “Хоршоог улсын бүртгэлд бүртгэлд бүртгүүлэхэд анхаарах асуудлаар мэдээлэл хийж заавар зөвлөмж өгсөн. шинээр хоршоо байгуулахаар холбогдсон 38 иргэнд гарын авлага материалыг олшруулж, хэвлэж гарын авлага болгон өгч мэдээллээр ханган ажилласан. 2024 оны 09-р сарын 21-нд зохион байгуулагдсан Малчдын зөвлөгөөнөөр ЗДТГазартай хамтран “Нээлттэй өдөрлөг” зохион байгуулж 115 иргэнд шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний үнэмлэх олголт, гадаад паспорт олголт, хоршоог улсын бүртгэлд бүртгэлд бүртгүүлэхэд анхаарах асуудлаар сургалт мэдээлэл хийж 51 иргэнд холбогдох хууль тогтоомжуудаар зөвлөгөө зөвлөмж өгч гарын авлага материал тараасан

12. Баян суман дахь улсын бүртгэгч нь 2024.04.01, 2024.04.05, 2024.04.08-ны өдөр зохион байгуулагдсан Цант 1-р баг, Өгөөмөр 2-р баг, Цавчир 3-р багуудын БИНХуралд хуваарийн дагуу оролцож, Тоон гарын үсгийн тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай гарын авлага, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай гарын авлага, мэдээллүүдийг 220 гаруй иргэнд хүргэж ажилласан. 2024 оны 5 сард Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 100 гаруй иргэдэд шинээр хоршоо байгуулахад бүрдүүлэх материал болон хоршооны талаарх мэдээ мэдээлэл хүргэж ажилласан. Баян суманд 2024.09.23-ны өдөр зохион байгуулагдсан “Алтан намар” арга хэмжээний үеэр 100 гаруй иргэдэд мэдээлэл хийж, гарын авлага тарааж ажилласан. 2024 онд Баянгийн мэдээ пэйж хуудсанд хялбаршуулсан гарын авлага, Улсын бүртгэлийн ерөнхий газрын тавьсан мэдээ, мэдээлэл, Сонгуулийн тухай хууль, иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай мэдээллийг тухай бүр хүргэж ажилласан. Нийт 6 шторк иргэдэд хүргэсэн. Тоон гарын үсгийн тухай, шинэ хоршоо байгуулах, хуулийн этгээдийн тухай гарын авлага, эд хөрөнгийн бүртгэлийн тухай гарын авлагуудыг өдөр тутмын ажлын хүрээнд иргэдэд 165 ширхэгийг тараасан. 2024 оны 11 сарын байдлаар 450 гаруй иргэдэд мэдээлэл хүргэж, үйлчилгээ үзүүлсэн байна

13. Борнуур суман дахь иргэний улсын бүртгэгч 2024.05.15-аас 2024.05.21-ныг хүртэл Нарт 4-р баг, Бичигт 3-р баг, Мандал 2-р баг, Өгөөмөр 1-р багийн БИНХ-д хуваарийн дагуу оролцож шинэ хоршоо-хөдөлгөөн аяны хүрээнд 440 гаруй иргэнд шинээр хоршоо байгуулахад бүрдүүлэх материал болон хоршооны талаарх гарын авлага тарааж мэдээ мэдээлэл хүргэж ажилласан. Борнуур суманд Нийгмийн салбарын явуулын үйлчилгээ 2024.09.23-ны өдөр сумын ЗДТГ-тай хамтран НЭЭЛТтэй ХААЛГА-ны өдөрлөг зохион байгуулсан. Үүнд Улсын бүртгэлийн байгууллагаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл иргэний улсын бүртгэл болон хуулийн этгээдийн бүртгэлээс бүртгэлийн үйлчилгээ болон бүртгэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг 100 гаруй иргэнд хүргэж ажилласан байна.

14. Бүрэн суман дахь иргэний улсын бүртгэгч Дунд сургуулийн 9-10-р ангийн 16 сурагчдад Зөрчлийн тухай хууль, Иргэний үнэмлэхийн болон гадаад паспортын

бүртгэлийн талаар мэдээлэл хийсэн. 2024.05.27-28 ны өдрүүдэд Баянцогт 2-р багийн ИНХуралд оролцож 28 иргэнд Эрдэнэхангай 4-р багийн 32 иргэнд шилжилт хөдөлгөөний бүртгэл, тоон гарын үсэг олгох, сонгуулийн нэрсийн жагсаалтаас өөрийн мэдээллээ хэрхэн харах болон бусад цаг үеийн талаархи мэдээллийг хүргэж, “Хоршоог улсын бүртгэлд бүртгэлд бүртгүүлэхэд анхаарах асуудлаар мэдээлэл хийж заавар зөвлөмж өгсөн. шинээр хоршоо байгуулахаар холбогдсон 7 иргэнд гарын авлага материалыг олшруулж, хэвлэж гарын авлага болгон өгч мэдээллээр ханган ажилласан. Мөн 2024 оны 3.20 нд дотоодын сургалтаар ЗДТГын албан хаагч ажилчиддад зөрчлийн тухай хууль, авлигын тухай хууль болон тоон гарын үсгийн талаарх мэдээлэл сургалтыг хийсэн.

15.Лүн суман дахь иргэний улсын бүртгэгч 2024.07.02-нд зохион байгуулагдсан “Налгар намар” арга хэмжээнд оролцсон 150 гаруй иргэнд иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн хууль тогтоомжийн талаар, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд зөрчлийн хуулиар авах арга хэмжээний талаар, хоршоо шинээр бүртгүүлэх болон нэмэлт өөрчлөлт, хасах бүртгэлтэй холбоотой мэдээллүүдийг тайлбарлан мэдээллийг хүргэж ажилласан. Мөн хоршоо байгуулахад бүрдүүлэх материалын жагсаалт болон мэдээллийг 160 гаруй иргэнд гаргаж өгч, шаардлагатай зөвлөгөө мэдээллийг хүргэж ажиллаж байна.

16.Эрдэнэсант суман дахь иргэний улсын бүртгэгч Баг тус бүрийн ИНХуралд Будаа оролцож гарын авлага материал тарааж ажиллав. Мөн ЕБС-ийн 11-А, 11-Б ангийн сурагчдад сургалт хийж 41 гарын авлага тараав. Нийт 58 хоршоо байгуулагдаж хоршоо тус бүрийн гишүүн бүрт зөвлөгөө өгч гарын авлага материал тарааж ажилласан.

17.Сэргэлэн суман дахь иргэний улсын бүртгэгч 2024.05.17 сумын ЗДТГ-аас зохион байгуулсан малчдын зөвлөлгөөнд ирсэн малчдад тоон гарын үсэг олгох, Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд Шинэ хоршоо хөдөлгөөн суманд ирж малчид, иргэдэд шинээр хоршоо байгуулах талаар мэдээлэл өгч хамтран ажилласан. 1,3,4,5 дугаар багийн малчин өрхүүдэд шинээр үүсгэн байгуулсан хоршоог УБ-д бүртгүүлэхэд зөвлөгөө өгч, давхардсан тоогоор 250 гаруй малчид хамрагдан, 40 иргэнд гарын авлага материал тараан ажилласан. 2024.11.18 байдлаар суманд хаягтай 11 хоршоо шинээр бүртгүүлсэн байна. 2024.05.28 Эрдэнэ-Уул 4 дүгээр багийн ИНХ- д оролцон давхардсан тоогоор 75 иргэнд шилжилт хөдөлгөөний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, гадаад паспорт олгох бүртгэл, тоон гарын үсэг олгох бүртгэл, Зөрчлийн тухай хуулийн талаар товч мэдээлэл хийж, иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хоршоо шинээр үүсгэн байгуулах талаар 35 иргэнд гарын авлага тараан иргэдийг мэдээллээр ханган ажилласан. МУИХ-ын сонгууль, орон нутгийн сонгуулийн нэрсийн жагсаалтаас сонгогч өөрийн мэдээллээ шалгах талаар цахимаар, утсаар, танхимаар тухай бүрд нь мэдээллээр ханган ажилласан. 2024.08.18-нд ЗДТГазраас зохион байгуулсан багуудийн нэгдсэн өдөрлөгт хамрагдсан 350 иргэнд улсын бүртгэлийн талаар товч мэдээлэл хийж, 50 иргэнд холбогдох хууль тогтоомжуудаар зөвлөгөө зөвлөмж өгч гарын авлага материал тараасан

3.2 Санхүүгийн үйл ажиллагааны тайлан:

Төв аймгийн Төрийн аудитын газраас 2024 оны 1-р улиралд тус хэлтсийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгаж зөрчилгүй санал дүгнэлт гаргасан бөгөөд зөвлөмж, албан шаардлага, акт байхгүй.

2024 оны 10 сарын 31-ны байдлаар 1,220,198,800 төгрөгийн санхүүжилт авч 1,206,449,300.23 мөнгөний төсвийн гүйцэтгэлтэй, 13,749,499.77 мөнгөний үлдэгдэлтэй байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДТГ-аас орон нутгийн нэмэгдэл цалингийн санхүүжилт 101,418,133 төгрөг орж 465,370.4 төгрөгийн үлдэгдэлтэй бусдыг зориулалтын дагуу зарцуулсан. Мөн УИХ-ын сонгуулийн үйл ажиллагааны зардалд 84,518,600 төгрөгийн санхүүжилт орж ирсэн үүнийг зориулалтын дагуу зарцуулсан болно. АНСДИТХ-ын сонгуулийн үйл ажиллагааны зардалд 80,584,600 төгрөгийн санхүүжилт орж ирсэнийг зориулалтын дагуу зарцуулсан. Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд нь аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан УБЕГ-т хүргүүлэн нэгтгүүлж байна.

Аймгийн ЗДТГ-аас нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн нэмэгдэл цалинд 101,418,133 төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

Зуунмод сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан 2024 оны төсөвт Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой 3,500,000 төгрөгийн төсвийг батлуулсан ба нэхэмжлэх үүсгэсэн.

3.3 Хүний нөөцийн үйл ажиллагааны тайлан:

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан орон тооны хязгаарт багтаан төрийн захиргааны /ТЗ/ 40, төрийн үйлчилгээний /ТҮ/ 5, гэрээт 5 нийт 50 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тайлангийн хугацаанд төрийн мэргэшсэн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, албан тушаал дэвшүүлэх, удирдах албан тушаалд томилохдоо мерит зарчмыг удирдлага болгон ажиллахад анхаарч сул орон тоо гарсан тохиолдолд хэлтэст ажиллаж байгаа албан хаагчид болон сумын ЗДТГ-т ажиллаж байгаа албан хаагчдаас томилуулах чиглэл барьж ажилласан. Энэ ажлын хүрээнд тайлангийн хугацаанд Алтанбулаг сумын улсын бүртгэгчийг төрийн албаны нөөцөөс, Мөнгөнморьт сумын улсын бүртгэгчээр сумын ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэнг шилжлүүлэн томилуулав.

Шинээр томилогдсон улсын бүртгэгчдийг хэлтэс дээр болон Зуунмод суманд ажлын 5 хоног дадлага хийлгэж, хууль тогтоомж, дүрэм журмыг судлуулсан.

Тус хэлтсийн Баянцагаан сумдад улсын бүртгэгч томилогдоогүй, Зуунмод сумын улсын бүртгэгч жирэмсний амралттай байгаа тул ойролцоо сумын улсын бүртгэгчид давхар эрх нээлгэн харьяалал харгалзах бүртгэлийг хөтлүүлж байна.

Тус хэлтсийн Аргалант, Архуст, Батсүмбэр, Баянчандмань, Эрдэнэсант, Заамар, Сэргэлэн 7 сумын улсын бүртгэгч нар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Зуунмод, Баянцогт, Лүн, Борнуур сумдын улсын бүртгэгч нар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэний улсын бүртгэлтэй хамт хөтөлж байна. Мөн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн 5 улсын бүртгэгчид, 1 улсын ахлах бүртгэгчид хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх нээлгүүлж, бүртгэл хөтөлж байна.

Хүний нөөцийн цахим системд албан хаагчдын цалин, хөдөлгөөн, бусад мэдээллийг тогтмол шинэчлэн оруулж байгаа бөгөөд шинээр томилогдсон албан хаагчдын мэдээллийг нэмж, томилогдсон болон чөлөөлөгдсөн тушаал шийдвэрийг сканердан оруулж байна. Түүнчлэн хүний нөөцийн тайланг УБЕГ-аар дамжуулан Төрийн албаны салбар зөвлөлд тогтоосон хугацаанд хүргүүлсэн.

Хэлтсийн даргын 2024 оны 01-р сарын 02-ны өдрийн 01 дүгээр “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, улсын бүртгэлийн үйлчилгээний стандартыг сайжруулах, үйл ажиллагаандаа мөрдөх, талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тушаалаар нийт албан хаагчдад 12 заалтаар үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.4 Хэлтэст ирсэн явсан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт:

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст өргөдөл, гомдлыг Засгийн газрын 11-11 мэдээллийн төв, Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн фэйсбүүк хаяг, Бүртгэлийн нэгдсэн лавлах утас 1800-1890, Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 70272999 утас, бичгээр бүх төрлийн хэлбэрээр хүлээн авч байна

Тайлангийн хугацаанд Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст ЗГ-ын 11-11 төвөөр дамжуулан ирүүлсэн 4 өргөдөл, гомдол ирүүлснээс Иргэний улсын бүртгэлтэй холбоотой 3 иргэний гомдол (*Тоон гарын үсэг авах гээд Төв аймгийн улсын бүртгэл дээр очтол заавал иргэний үнэмлэх болон ухаалаг утас байх ёстой гээд өгсөнгүй, гадаад паспорт дээр ТГҮ авмаар байна, Төв аймгийн Улсын бүртгэлт гомдол гаргаж байна. Миний эхнэр 9 хоногийн өмнө гадаад паспорт захиалсан. Тухайн үед ажлын 7 хоногт гаргана гэсэн ба өнөөдөр гадаад паспортоо авах гээд очтол 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр гарна гэсэн хариу өгсөн байна. Тухайн үедээ ингэж удахаа хэлсэн бол Улаанбаатар хотод очин шуурхай захиалах байсан. Хариуцлагагүй байдлаас үүдэн төлөвлөсөн бүх ажлууд хойшилж хохирч байна, Улаанбаатар хотоос Төв аймгийн Эрдэнэ суманд шилжих гээд 7 дугаар сарын 20-нд нүүж ирсэн юм. Шилжих хөдөлгөөнөө хийлгэх гэхэд улсын бүртгэгч нь амралтаа авсан, амралтаасаа иртэл хүлээ гээд байна. Гэтэл ажлыг нь орлож байх хүн байх ёстой шүү дээ. 8 дугаар сарын 15-наас*

шилжих хөдөлгөөн зогсож. хүүхдийн цэцэрлэг сургуулийн бүртгэл эхлэх гэж байгаа үед ийм хүнд суртал гаргаж болохгүй. Маш яаралтай энэ асуудлыг шийдэж өгнө үү гэх)

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 1 иргэний гомдол (төрсөн дүүгийнхээ газрын гэрчилгээг авах гээд иргэний үнэмлэхийг нь аваад очтол журмын дагуу ажиллаж байна гээд өгсөнгүй гэх) гомдол тус тус ирүүлснийг хуулийн хугацаанд буюу ажлын 3 хоногт багтаан албан бичгээр хариу өгч шийдвэрлэсэн. Эдгээр гомдлууд нь улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоогүй, иргэд зөвхөн өөрийн эрх ашгийн төлөө төрийн байгууллагын холбогдох дүрэм, журмыг зөрчсөн үйлдэл хийхийг шаардсан гомдлууд байсан. Хугацаа хоцорсон, шийдвэрлээгүй өргөдөл, гомдол байхгүй.

2024 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст нийт 990 бичиг ирсэн ба 1066 албан бичиг явуулсныг бүртгэж архив, албан хэрэг хөтлөлтийн зохих журмын дагуу бүртгэл хөтлөн, Edoc албан бичгийн бүртгэлд бүртгэн дугаарлаж хяналтын карт хэвлэсэн. Нийт ирсэн бичгээс 645 хугацаатай, хариутай бичиг байсныг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж хариуг хүргүүлсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр ирсэн албан бичгийн тоо **478**, явуулсан бичгийн тоо **573**, олгосон лавлагааны тоо **3161**, хуулбарсан баримтын тоо 1569

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр чиглэлээр ирсэн албан бичгийн тоо **203**, явуулсан бичгийн тоо **191**, олгосон лавлагааны тоо 81,

Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр ирсэн албан бичгийн тоо **309**, явуулсан бичгийн тоо **302**, олгосон лавлагааны тоо 647, хуулбарсан баримтын тоо 1279 тус тус байна.

2024 онд тус хэлтэст УБЕГ-ын даргын /А/ тушаал 7, /Б/ тушаал 22 батлагдан ирсэн батлагдан ирсэн байна.

Тайлангийн хугацаанд хэлтсийн даргын А тушаал 16, Б тушаал 12 батлагдан гарсан байна. Хүний нөөцийн томилгоотой холбоотой өргөдөл, гомдол байхгүй.

3.5 Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах талаар хийж хэрэгжүүлсэн ажил

Тус хэлтсийн 2024 оны Авлигын эсрэг төлөвлөгөөг 12 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлангийн хугацаанд АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэлтсийн вэб хуудас болон пэйж хуудас, сурталчилгааны самбарт байрлуулсан. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар 10 хавсралт бүхий “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах” 5 дугаар тогтоол батлагдсантай холбогдуулан Авлигатай тэмцэх газраас зохион байгуулагдсан цахим сургалтанд хэлтсийн дарга Н.Энхбат хамрагдсан.

Тус хэлтсээр үйлчлүүлж буй иргэдээс 2024 оны 03 сарын 04-нөөс 05 сарын 31-ний хооронд төрийн үйлчилгээний сэтгэл ханамж, төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйн талаар QR код уншуулан илгээлгэж судалгаа авсан. Уг судалгаанд 100 гаруй иргэн хамрагдаж саналаа өгсөн. Санал өгсөн иргэдийн 85% албан хаагчдын үйлчилгээнд талархсан, 15% нь цаашдын ажил үйлчилгээнд анхаарч сайжруулж ажиллах талаар санал өгсөн байна. Энэ судалгааны үр дүнгийн дагуу албан хаагчдад зөвлөгөө мэдээлэл өгч “Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүй”-н сургалтанд 32 албан хаагчийг хамрууллаа.

Байгууллагын төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж улсын бүртгэлийн хэлтсээс улс орон нутгийн төсөвт оруулсан орлого, шилэн дансны мэдээллийг хэлтсийн цахим хуудас сошиал сүлжээ <http://tuv.burtgel.gov.mn/> веб хуудас, “Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудсанд байршуулан олон нийтэд түгээн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 31 мэдээллийг байршуулж олон нийтэд хүргэсэн байна.

Тус хэлтсийн 2024 оны Гэмт хэрэг, терроризмоос урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг 5 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зорчин өнгөрөгч иргэдийн аюулгүй орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчил гарсан тохиолдолд таслан зогсоох, илрүүлэх, аюулгүй амар амгалан орчин бүрдүүлэх зорилгоор байгууллагын гадна талд 2 хяналтын камер 2024 оны 3-р сард ашиглалтанд орууллаа.

2024 оны 06 дугаар сарын 04-ны өдөр Аймгийн цагдаагийн газрын эрүүгийн мөрдөгч цагдаагийн дэслэгч Б.Отгонбаяр “Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт урьдчилан сэргийлэх” сэдвээр, Эдийн засгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Л.Ган-Эрдэнэ “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” сэдвээр цахим сургалт тус тус зохион байгуулж хэлтсийн 16 албан хаагч, сумын 24 улсын бүртгэгч нийт 44 албан хаагч сургалтанд хамрагдлаа.

Тус хэлтсийн төрийн захиргааны 37, нягтлан бодогч 1 албан хаагчдын 2023 оны хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч, хянан баталгаажуулсан. 2024 оны 11-р сарын 20-ны байдлаар Төв аймгийн Баянцагаан сумын улсын бүртгэгчид томилогдоогүй байна. Мөн Алтанбулаг сумын улсын бүртгэгчээр 2024 оны 04 дүгээр сарын 22-оос шинээр томилогдсон Д.Гансүх,

Мөнгөнморьт сумын улсын бүртгэгчээр 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс шинээр томилогдсон А.Хишигдулам, хэлстийн ерөнхий нягтлан бодогчоор 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрөөс шинээр томилогдсон С.Лхамсүрэн нарын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулав. Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахтай холбоотой тус хэлтсийн албан хаагчдад зөрчил гараагүй.

3.6 Аймаг, орон нутгийн бусад байгууллагуудтай хамтран ажилласан байдал:

Зуунмод сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан 2024 оны төсөвт Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой 3 500 000 төгрөгийн төсвийг батлуулсан ба нэхэмжлэхийг үүсгэсэн. Тус хэлтсийн дансанд хараахан орж ирээгүй байна.

Төв аймаг дахь ЗХ-ий 016-р бригадын нийгмийн ажилтны ирүүлсэн хүсэлтийн дагуу 2024 оны 01 сарын 23-нд тус цэргийн ангид очиж ажиллан 26 цэргийн иргэний үнэмлэхийн лавлагааг өгсөн.

Баянцагаан сумын Засаг дарга, ЗДТГ-тай хамтран ажиллаж улсын бүртгэгч нь томилогдоогүй байгаа аймгийн төвөөс 70км алсад байрлалтай Баянцагаан суманд 2024 оны 01 сарын 25-нд очиж ажиллан 95 иргэнд тоон гарын үсэг олголоо.

2024 оны 02 сарын 28-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн Б.Тэмүүжиний /уж08212911/-ийн асран хамгаалагчийн хүсэлтээр Зуунмод сумын 1-р баг дахь гэрт нь очиж БДӨ-ийн бүртгэлд, 2024 оны 03 сарын 05-нд хөлөө гэмтээсэн иргэн П.Нямаа /нэ56020104/-гийн хүсэлтээр Зуунмод сумын 3-р баг, баянхошуунд байрлах гэрт нь очиж гадаад паспортын бүртгэлд, 2024 оны 05 сарын 31-нд Зуунмод сумын өндөр настан П.Буянхүү гуайн гэрт нь очиж гадаад паспортын бүртгэлд, 2024 оны 09 сарын 18-нд Зуунмод сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэн Туяа /ню731022/-д гэрт нь очиж ТГҮ олгож, 2024 оны 10 р сарын 23-нд Заамар сумын хайлааст багт очиж ажиллан 2 төрсний бүртгэл, 4 шилжилт хөдөлгөөний бүртгэл бүртгэж сум, багтай хамтран ажиллав.

2024 оны 05 сарын 20, 10 сарын 22-нд тус тус Мөнгөнморьт сумын хорих 417-р нээлттэй хорих ангид очиж ажиллан 1 гэрлэлт дуусгавар болсоны, 25, 45 насны сунгалт 11, иргэний үнэмлэх шинээр авах 1, дахин авах 20, ТГҮ-2 бүртгэл хөтөлсөн.

2024 онд сүлжээний зөөврийн төхөөрөмж ашиглан нийт 180 улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна

Төв аймгаас 2024 оныг “Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Баянцогт улсын бүртгэгч нь сумын давсан орлогоос 500.000 төгрөгийг төсвийг сумын ИТХ-аар батлуулан гэрлэлт батлах ёслолын буланг шинээр тохижуулсан байна. Аймгийн урианы жилийн ажлын хүрээнд ГБХЗХГ, сумдын Засаг даргын тамгын газар, нийгмийн бодлогын мэргэжилтэн нартай хамтран “Ёслолтой гэр бүл” арга хэмжээний хүрээнд гэр бүлийн андгай өргүүлж, гэрлэлтийн гэрчилгээг ёслол төгөлдөр гардуулах арга хэмжээг 20 суманд зохион байгуулж 63 хос хамрагдсан.

Түүнчлэн аймгийн ГБХЗХГ, сумдын Засаг даргын тамгын газар, нийгмийн бодлогын мэргэжилтэн нартай хамтран “Үндсэн хуулиа баталж эрх чөлөөгөө

тунхагласны баяр"-ийг тохиолдуулан 16 нас хүрсэн хүүхдүүдээр “Иргэний андгай” өргүүлж, иргэний үнэмлэхийг ёслол төгөлдөр гардуулах үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг бөгөөд 2024 онд 16 суманд энэ үйл ажиллагааг зохион байгуулж нийт 308 хүүхдээр андгай өргүүлж, гарын бэлэг, дурсгалын зүйл гардуулан өгсөн.

Албан хаагчдын болон түүний гэр бүлийн гишүүдийн хүрээнд байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний судалгааг гарган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 албан хаагчид 50.000 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн.

Батсүмбэр сумын ЗДТГ-тай хамтран 2024 оны 11-р сарын 18-ны өдөр Г.Жамух /нб24301598/ нь сумын төрсний бүртгэлийн 100 дахь хүүхдээр бүртгүүлсэн тул, Засаг даргын нөөц хөрөнгөөс 50,000 төгрөгний хүүхдийн ирээдүйн боловсролын хадгаламжийн дэвтэр, Батламж, төрсний гэрчилгээг гардуулсан.

УБЕГ-аас зохион байгуулсан “Хүүхдийн төлөө аянд” бүх албан хаагч нэгдэж 500.000 мянган төгрөгийн хандив цуглуулж, хандивын үйл ажиллагаанд оролцсон

Аймгийн Төрийн банктай хамтран ажиллаж албан хаагчдын гэр бүл, хүүхдийн бүртгэлийн дэлгэрэнгүй судалгааг гарган энэ онд 1-р ангид элсэн орсон 4 хүүхдэд хичээлийн багц хэрэгсэл, хүүхэд тус бүрт Төрийн банкны 50.000 төгрөгийн хадгаламжийн дэвтэр нээлгэн гардуулан өгсөн.

Зуунмод сумын ЗДТГ-тай хамтран ажиллаж 2024.10.30-ны өдөр байгууллагын хүүхдүүдийн дунд “Үлгэрийн баатруудын дүрд” арга хэмжээг 500.000 төгрөгийн зардал гаргаж зохион байгуулсан

УБЕГ болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, уралдаан тэмцээнд тус хэлтсийн албан хаагчид идэвхтэй оролцдог ба 2024 онд УБЕГ-аас зохион байгуулсан “Монгол бичгийн эссэ бичлэг”-ийн уралдаанд Цээл сумын улсын бүртгэгч Г.Мөнхцэцэг 1-р байр, аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс зохион байгуулсан Хууль сахиулах байгууллагуудын спортын тэмцээнд тус хэлтсийн баг 1-р байр, сумдын ЗДТГ-аас зохион байгуулсан “Ёс зүйтэй албан хаагч” уралдаанд Баянхангай сумын улсын бүртгэгч Б.Мөнхтуяа, Баянцогт сумын улсын бүртгэгч Л.Оюунтуяа нар 1-р байранд тус тус шалгарсан.

Тус хэлтсийн улсын бүртгэгч Б.Цэндсүрэн нь Төв аймгийн ЗДТГ-аас хэрэгжүүлж буй түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамрагдаж Төв аймгийн Орон нутгийн өмчийн газартай 89.850.000 төгрөгний үнэтэй 45.9 мкв 2 өрөө байрны түрээслээд өмчлөх гэрээ байгуулж, түлхүүрээ хүлээн авсан.

ТӨВ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Аймгийн телевизээр мэдээлэл хүргэж буй зураг:

TBS телевиз
Бөдөр · 🌐

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс Монгол Улсын Их хурлын сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтыг нягталж шалгах ажлыг хийж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын election.burtgel.gov.mn сайтаар иргэд өөрийн болон өөрийн оршин сууж буй хаягийн бүртгэлээ шалгах боломжтой. 5-р сарын 01ний байдлаар Төв аймгийн 226 иргэн энэ сайтаар өөрийн мэдээлэлтэй танилцсан ба 15 иргэн мэдээлэл зөрүүтэй тухай хүсэлт илгээснийг иргэдтэй холбогдож зөрчлийг арилгажээ.



TBS телевиз
Бөдөр · 🌐

Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс Монгол Улсын Их хурлын сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтыг нягталж шалгах ажлыг хийж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын election.burtgel.gov.mn сайтаар иргэд өөрийн болон өөрийн оршин сууж буй хаягийн бүртгэлээ шалгах боломжтой. 5-р сарын 01ний байдлаар Төв аймгийн 226 иргэн энэ сайтаар өөрийн мэдээлэлтэй танилцсан ба 15 иргэн мэдээлэл зөрүүтэй тухай хүсэлт илгээснийг иргэдтэй холбогдож зөрчлийг арилгажээ.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын election.burtgel.gov.mn сайтаар иргэд өөрийн болон өөрийн оршин сууж буй хаягийн бүртгэлээ шалгах боломжтой

👍 2

Нээлттэй өдөрлөг зохион байгуулсан зураг:


Мөнгөнморьт сум



Борнуур сум



Эрдэнэ сум



Гэр бүлийн андгай өргүүлж буй зураг:







ИТА нарт онлайн сургалт зохион байгуулж буй зураг:





Иргэний улсын бүртгэл, сонгуулийн хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хүргэж буй видео шторк:



Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс

4-р сарынын 10

ИРГЭНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ ТҮР ЗОГСООХ ТУХАЙ!!!

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25.1 дэх хэсэгт “Иргэний шилжилт хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоож санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ” гэж заасан.

2024.04.29-ний өдрөөс эхлэн 2024.06.29-ний өдрийг хүртэлх хугацаанд шилжилт хөдөлгөөний бүртгэл хийгдэхгүй болохыг анхаарна уу!

ИРГЭНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ ТҮР ЗОГСООХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25.1 дэх хэсэгт “Иргэний шилжилт хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоож санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ” гэж заасан.

ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ ЗОГСОХ ХУГАЦАА: 2024.04.29

ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ СЭРГЭЭХ ХУГАЦАА: 2024.06.29

Иймд иргэд та бүхэн дээрх хугацаанаас өмнө шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгэнэ үү.



арах





Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс

4-р сарынын 2 · 🌐



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ
Сонгогчдын нэрийн жагсаалт




Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс

11-р сарынын 14 өдрийн 11:51 цаг · 🌐



@followers



Иргэний андгай өргүүлж буй зураг:



